



Улсын хилийн онол тгүх

УЛСЫН ХИЛИЙГ ХАРУУЛААР ХАМГААЛАХ НЬ

(Үргэлжлэл. Түрүүч нь 2000 оны №1-т)

Монгол улсын Хилийн тухай хуульд дүн шинжилгээ хийж үзвэл улсын хил хамгаалалт нь :

- Улсын хилийн дэглэмийг сахиулах,
- Улсын хил орчмын дэглэмийг сахиулах гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж байна.

Энэ арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулагч нь хил хамгаалах байгууллага юм. Хил хамгаалах байгууллага нь улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахдаа:

- Улсын хилийг арчлан хамгаалах
- Зорчигч тээврийн хэрэгслийг улсын хилээр шалгаж нэвтрүүлэх
- Хил орчимд явагдаж байгаа ажил үйлдвэрлэл, хил дамнасан байгууламжийг ашиглах явдал хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих,
- Хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын Олон улсын гэрээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Хилийн бүс, зурваст тогтоосон журмыг сахиулах,
- Хилийн боомтод тогтоосон журмыг сахиулах,
- Хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын Олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн таслан зогсоох зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд:

- Улсын хилийн бүс, зурваст хилийн застав, харуулаас хилийн манаа томилон үүрэг гүйцэтгүүлэх,
- Зарим үед оршин сууж, ажил үйлдвэрлэл эрхэлж байгаа хил хамгаалахад туслах хүчний гишүүдээр орчинд нь тусгай үүрэг даалгавар гүйцэтгүүлэх эсвэл тэднээс хилийн манаа

- томилон тодорхой чиглэл буюу хэсэгт үүрэг гүйцэтгүүлэх,
- Хилийн бүс, зурваст иргэдийн бичиг баримтыг шалгах
- Хилийн төлөөлөгчийн уулзалт хийж асуудал шийдвэрлэх
- Хил залгаа улсын хилийн ажилтнуудтай хамтран хилээ болон хилийн зөрчлийг шалгах,
- Орон нутгийн иргэдэд хилийн хууль тогтоомж сурталчлах,
- Хилийн эрэл явуулах,
- Өдөөн хатгалгатай тэмцэх,
- Дайсны хорлон сүйтгэх тагнуулын бүлэг (ХСТБ)-ийг устгах,
- Зэвсэгт халдлагыг няцаах
- Инженерийн байгууламж барьж ашиглах,
- Цахилгаан дохиоллын систем тавьж ашиглах,
- Телевиз радиолокацийн систем ашиглан ажиглалт хийх гэх мэт олон арга хэмжээ авдаг.

Бүлэг тус бүрийн агуулгыг тодорхойлбол:

- Хилийн тухай хууль тогтоомжийг сахиулах үйл ажиллагаа,
- Хилийн төлөөлөгчийн ажиллагаа,
- Эрлийн ажиллагаа,
- Цэргийн арга хэмжээ,
- Инженер техникийн арга хэмжээ гэсэн таван үндсэн агуулгад хуваагдаж байна.

Энэ бүхнээс үзвэл улсын хил хамгаалалт гэж улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахын тулд хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах зорилгоор хил хамгаалах байгууллага хилийн бүс, зурвас, боомт газарт хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын Олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомжийг сахиулах, хилийн төлөөлөгч, хилийн эрэл, цэрэг, инженер техникийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг хэлж байгаа нь тодорхой байна.

Бодит байдлаас дүгнэлт хийвэл улсын хил хамгаалалт нь янз бүрийн нөхцөл, цагийн байдалд өөр хоорондоо ялгагдах өвөрмөц байдлаар явагддаг байна.

Үүнийг XX зууны Монголын хил хамгаалалтын жишээн дээр үзье. XVII зууны эцсээс XIX зууны эцэс хүртэл Манжийн дарлалд байсан үеийн Монголын хил хамгаалалт Хаант Орос, Манжийн эзэнт гүрэн хоёрын хил дээр цэрэг улс төрийн тайван нөхцөлд явагдаж байснаа XX зууны эхэн үеэс Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж Монголчууд Хаант Оростой ямар нэг хэмжээгээр холбоо тогтоож эхэлсэн нь тухайн үеийн хилийн цагийн байдал хил хамгаалалтын агуулгад чанарын өөрчлөлт гаргахад хүргэсэн билээ.

1911 онд Богд хаант Монгол улсыг тунхагласнаар хил хамгаалалт жинхэнэ Монгол төрийн бодлого болон хэрэгжиж эхэлсэн юм. Энэ үеэс эхлэн Монгол орны хилийн дотоод гадаад орчин нөхцөлд зарим үнэлэлт өгье.

1. **1911-1920 он.** Хаант орос улстай харилцаа хэвийн, Хятадын зүгээс Монголын тусгаар тогтнолд заналхийлэн түрэмгийлэх бодлого явуулан улмаар Богд хаант төрийг түлхэн унагааж цэргийн харгис дэглэм тогтоосон үе. Ийм тохиолдолд Богд хаант улсын төрөөс хаант оростой хиллэсэн хилээ цөөн хүний бүрэлдэхүүнтэй харуулаар, бусдын халдлага түрэмгийлэдд өртөгдсөн өмнөд хилээ цэргийн хүчээр хамгаалж байгаад Хятадын цэргийн дарангуйлалд автаж эрх чөлөөгөө алдсанаар 1921 онтой золгожээ.

2. **1921 онд эрх чөлөөгөө байлдан олж гамин болон цагаантны үлдэгдлийг хөөн гаргаж нутаг дэвсгэрээ чөлөөлсөн 1922 он хүртэл** хугацаа нь дайны байдалтай үе байсан бөгөөд Зөвлөлт Орос улстай хэвийн харилцаатай хэдий ч хойд хилээр цагаантнууд орж гарсан түгшүүртэй, өмнө зүгээс алдагдсан байр сууриа сэргээх гэсэн эрмэлзэл бүхий Хятадын халдлага хэвээр байлаа. Энэ үед зарим хилийн харуулуудыг өргөтгөх ард иргэдийг цэргийн албанд дайчлах замаар ардын журамт цэргийг зохион байгуулж зэвсэгт тэмцлийн аргаар газар нутгаа чөлөөлөн хил хязгаараа хамгаалав.

3. **1923-1927 онд** Орос, Монголын харилцаа хэвийн, Хятад газар нутгийн маргаан хийж манай улсын нутаг дэвсгэрт нэгдэлсэн хэвээр, хилийн зөрчил их хэмжээгээр гарч байсан тул улсын хилийг нэлээд их хүчээр хамгаалах шаардлагатай байв. Ийм учраас хязгаарын морин цэргийн хороо гэдгийг байгуулан өмнөд хилийн харуулын араар суулгаж хилээ давхар хамгаалалттай болгосны зэрэгцээ хил хамгаалалтын бэлтгэл хүчийг зузаатгав.

4. **1928-1932 он.** Хойд хилийн Туватай хил нийлсэн хэсэгт малын хулгай их хэмжээгээр гарч Монгол Тувагийн хилийг тогтоох асуудал сунжирав. Зүүн, зүүн өмнөд хил түгшүүртэй болж Барга болон Өвөрмонголын хошууд Монголын нутагт түрэн орж нутаг ус булаалдах, хувьсгалын эсрэг хөдөлгөөн гарч олон мянган айл мал хил даван нүүдэллэж тус улсын тусгаар тогтнолд аюултай нөхцөл байдал бий болов. Үүнтэй холбогдуулан Монгол улсын хил зах хязгаарын хамгаалалтыг 1928 оны 12 сарын 1-нээс Ардын цэргийн мэдэлд шилжүүлэв. Энэ үед хилийн хуучин харуулуудын хажуугаар Ардын цэргийн салбарууд хил хамгаалж бусад хэсэг нь бэлтгэл хүч

болон үйл ажиллагаа явуулж байв. Япон 1930-аад оны эхээр Хятадын зүүн хойд хэсгийг бүхэлд нь эзлэн авч "Манж-Го" улс байгуулаад Монголын дорнод хилийн дагуу цэргийн зориулалттай барилга байгууламж барих зэргээр дайны бэлтгэлийг шууд хийж эхлэв. Баруун хязгаараар олон тооны нүүдэлчин казахууд орж ирж нутаглаад удалгүй нутгийн хэдэн хүний амь нас хөнөөсний улмаас тэднийг нутгийн гүн рүү татах болж, нүүдэлчин казахууд буцаж дүрвэн баруун хилд дээрмийн халдлага ихсэв. Ингэж цагийн байдал эрс хурцдаж дайны ирмэгт тулж ирмэгц улсын хил хамгаалалтыг ДХГ-т шилжүүлэн Хилийн цэрэг гэсэн тусгай зориулалтын цэргээр хилээ хамгаалж ардын цэргийг хил хамгаалалтаас чөлөөлж дайны бэлтгэл хийлгэжээ.

5. 1933-1952 он. Дайны өмнөх, дайны болон дайны дараах гэсэн 3 үеийг хамарсан юм.

А. Дайны өмнөх үед хилийг тусгай зориулалтын цэрэг хамгаалж, Ардын журамт цэрэг болзошгүй дайнд бэлтгэж байв.

Б. Харин дайны үед хилийн цэрэг хамгаалж байгаа хэсгийнхээ байрлалаар Ардын журамт цэргийн бүрэлдэхүүнд орж хариуцсан хэсгээ байлдан хамгаалж байв. 1936 оны найрамдал хамтын ажиллагааны гэрээ ёсоор Зөвлөлтийн цэрэг Монголын тусгаар тогтнолыг хамгаалахад туслаад буцаж гарав.

В. Дайны дараагаар хилийн хамгаалалтаа урьдын адил хилийн цэргээр ицэтгүүлж хоёр их хөрштэйгээ сайн хөршийн найрамдалт харилцаатай болмогц хилийн цэргээ (хил хамгаалах тусгай зориулалттай цэрэг) татан буулгав.

6. 1953-1966 он. 60-аад оны эх хүртэл аж ахуйн чанартай зөрчлүүд гарч байсныг хил залгаа улсынхаа хилийн төлөөлөгч нартай хамтран шийдвэрлэж улсын хилийн районд хяналт тавих журмаар хамгаалж байв. Харин 1960-аад оны эхнээс өмнөд хилийн байдал тогтворгүй болж эхлэн нутаг дэвсгэр хил хязгаарын маргаан гарч цаашид хүндрэх төлөвтэй болсныг БНХАУ-тай хил тогтоосноор түр ч гэсэн шийдвэрлэв.

7. 1967-1989 он. ЗХУ-тай найрамдал сайн хөршийн харилцаатай. БНХАУ-тай урьд байсан харилцаа үндсээрээ зогссон. Өмнөд хилийн дагуу Хятадын цэргийн томоохон бүлэглэлүүд байрласан, тагнан турших ажиллагаа үлэмж ихэссэн үе байлаа. Энэ үед дайсны тодорхой бүлэглэлийг бие даан устгах бэлтгэлтэйгээр хилийн цэргийг дахин байгуулж улсын хилийг хамгаалав. Зэвсэгт хүчин бүхэлдээ болзошгүй дайнд бэлтгэж, найрамдал хамтын ажиллагааны гэрээний дагуу ЗХУ-ын цэргийн зарим анги нэгтгэлүүд

Монгол, Хятадын хилийн дагуу ирж байрлав.

8. **1990 оноос хойш** хоёр их хөрштэйгээ бие биенээ хүндэтгэн харилцан итгэлцсэн байр сууринаас найрамдал хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж байна. Энэ үед өмнөд хилд хуримтлуулсан хүч хэрэгслээ задалж бүх хилээ харж хамгаалдаг болов. Зөвлөлтийн цэрэг монголын нутгаас гарч, манай зэвсэгт хүчин зөвхөн өөрийгөө хамгаалах зорилготой цомхон чадварлаг байх чиглэлээр өөрчлөгдөж байна.

Дээр дурьдсан үечлэлүүд, түүний хамгаалалтын шинж чанарыг хооронд нь харьцуулан судалбал дараах дүр зураг харагдаж байна. Монгол улсын хил дээр үүсч бий болсон цагийн байдал нь:

- Хил залгаа улстай тогтсон харилцааны шинж байдал,
- Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдалд хохирол учирч болзошгүй байдал,
- Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдалд хохирол учирсан эсэх,
- Хилийн зөрчил идэвхижсэн байдал гэсэн 4 үндсэн шинжээр өөр хоорондоо ялгагдаж байна.

Эдгээр шинжүүдийг харьцуулан дүгнэлт хийхэд

- Хилийн цагийн байдал харьцангуй тайван ,
- Тайван боловч хилийн зөрчил идэвхижсэн
- Улс төрийн харилцаа эрс муудаж Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдалд хохирол учирч болзошгүй болсон
- Хилийн цагийн байдал эрс хурцадсан
- Дайны буюу дайн бүхий байдал бий болсон зэрэг хилийн цагийн байдлын 5 зэрэглэл бий болсон байна. Энэ бол бодит байдлаас хийсэн дүгнэлт, объектив үнэлгээ юм.

Оросын цэргийн шинжлэх ухаанд цэрэг-улс төрийн цагийн байдлыг тайван, хурцадмал, хямралт, мөргөлдөөнт, дайны байдал гэж 5 ангилж үздэг. Эдгээр нь тус тусын онцлог шинжтэй бөгөөд гол ялгаа нь улс хоорондын харилцаа, дайнд бэлтгэх ажиллагаа, өдөөн хатгалга, цэргийн түрэмгийлэл үйлдэж байгаа байдлаар илэрдэг. Цагийн байдлыг цэрэг- улс төрийн, хилийн гэсэн хоёр төрөлд ангилах бөгөөд энэ хоёр төрлийн зэрэглэлийг хооронд нь харьцуулан жишиж ажиглавал цэрэг, улс төрийн байдал тайван байхад хилийн цагийн байдал тайван бус, хилийн зөрчил идэвхижсэн байх жишээтэй байна. Цэрэг, улс төрийн байдал хурцадсан гэдгийн цаана цэрэг улс төрийн хурцадмал, хямралт, мөргөлдөөнт байдлууд багтдаг бөгөөд хилийн цагийн байдал хурцадсан гэсэн ойлголт ч

энэ хүрээнд хамаарч байна. Дайны үе нь цэрэг улс төрийн цагийн байдлын хувьд ч хилийн цагийн байдлын хувьд ч адил утгатай юм. Энэ нь хилийн цагийн байдлын янз бүрийн нөхцөлд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулж байсан туршлага цэрэг, улс төрийн цагийн байдал хурцадсан үед улсын хил хамгаалах байгууллагаас явуулах үйл ажиллагааны талаар судалсан бүтээлүүдээс харагдаж байна. Иймээс цэрэг улс төрийн цагийн байдлыг улсын хил хамгаалалтад ашиглахдаа тайван, цэрэг улс төрийн цагийн байдал хурцадсан, дайны гэсэн гурван ангиллаар авч үзэх нь илүү зохимжтой юм.

1911 оноос хойш улсын хил хамгаалалтын цагийн байдлын янз бүрийн нөхцлүүдэд ашиглаж байсан хүч хэрэгслийг харьцуулан үзэхэд аль ч тохиолдолд улсын хилийг тусгай зориулалтын хүч хэрэгслээр, тэр нь хилийн цагийн байдал эрс хурцадсан үед зэвсэгт хүчний оролцоотойгоор, дайны үед зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орж хамгаалдаг байсан нь тогтоогдсон байна. Мөн хил хамгаалалтад ашиглагдаж байгаа хүч хэрэгсэл зориулалт ба боломжоороо эрс ялгагдаж байна. Мэргэжлийн бус удирдлагатай тусгай зориулалтын хүч (өрхийн цагдаа, суман харуулууд) нь аливаа зөрчлөөс сэрэмжлэх, хянах шалгах зохицуулахад чиглэсэн, мэргэжлийн удирдлагатай тусгай зориулалтын хүч (хилийн цэрэг) нь хилийн болон хил орчмын дэглэмийг чандлан сахиулах зорилгоор хилийн зөрчил, орон нутгийн чанартай бага зэргийн хүчний өнгөлзлөгийг таслан зогсооход чиглэсэн. бэлтгэл хүчнүүд гадны түрэмгийллийг няцааж нутаг дэвсгэр хил хязгаарын бүрэн бүтэн байдлыг хадгалан үлдэхэд чиглэсэн гэх мэт тус тусын онцлог үүрэгтэй байжээ.

1990-ээд оны эхээр дэлхий нийтийг хамарсан эрс өөрчлөлт түүний дотор Монгол улсад өрнөсөн ардчилал шинэчлэлийн үйл явц хилийн цагийн байдал, олон улсын цэрэг улс төрийн нөхцөл байдлыг үндсээр нь өөрчилсөн тул үүнийг дагаж хил хамгаалалтыг тухайн цаг үед нь тохируулж боловсронгуй болгож өөрчлөх зайлшгүй шаардлага бий болсон юм. Хилчин бүр энэ зорилтыг шийдэхийн тулд мэдэж чадах бүхнээ хийж нэгэн зорилгод нэгдэж чадсанаар зарим нэг амжилтад хүрлээ. Үүний нэг нь улсын хилийг хилийн харуулаар хамгаалах болсон явдал мөн.

Хилийн зөрчил эрс идэвхжиж шинж байдал нь үндсээрээ өөрчлөгдсөн, улс орны эдийн засгийн чадавхи буурсан, улсын хилийг эргэн тойронд нь хяналтын нэгдсэн системд хамруулах, улсын хилийг мэргэшсэн албаны харуул хамгаалалттай болгох шаардлагууд тавигдсан зэргээс хилд 20-30 км хол байрласан 60-

70 км хэсэг хариуцсан заставаас морь, тэмээн уналгатай 2-3 хилчнийг явуулж хилээ хамгаалдаг хуучин арга нэгэнт тохирохоо больжээ.

Иймд 7-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн, эсвэл зохих чадвар эзэмшсэн ахлагчаар удирдуулсан уналга холбоо, байр сууцаар бүрэн хангагдсан алба, амралт, сургалтыг нь тусгай цагийн хуваариар зохицуулж албаны ачааллыг 8 цагаас хэтрэхгүй, амралтыг 8 цагаас дутуугүй байх боломжийг хангаж хариуцсан хэсэгтээ цагийн байдлын өөрчлөлтийн үед бие даан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх эрхээр хангагдсан хилийн харуулыг байнгын нэг байрлалд эсвэл цагийн байдал өрнөсөн чиглэлд шилжин байрлах бололцоотойгоор 1989 оноос эхлэн туршиж нийт отряд заставт 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Хилийн харуул нь аль нэг чиглэлд түр хугацаагаар гараад буудаг хилийн манаа биш хилийн тодорхой хэсгийг байнгын хамгаалалтад байлгадаг, өөрөөсөө ямар ч төрлийн манааг томилон үүрэг гүйцэтгүүлж чадах, харуулын байрлалаасаа хариуцсан хэсэгтээ 24 цагийн турш цэргийн хяналт зохиодог хил хамгаалалтын анхан шатны нэгж юм. Хилийн харуул нь хил хамгаалалтын нэгж болохыг 1994 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн 81 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын хил хамгаалалтын дүрэм"-д баталгаажуулсан билээ.

Хил хамгаалах байгууллага цэрэг улс төрийн цагийн байдлын ямар ч нөхцөлд зохицон хил хамгаалах боломжийг хилийн харуул бүрдүүлж байна. Ямарч үед нэг хоёр хүн хилийн болон хил орчмын дэглэмд хяналт тавихаас эхлээд дайсны тасаг хүртэл хүчийг няцаах, салаа хүртэл хүчийг тогтоон барих боломжтойгоор хилийн харуулын бүрэлдэхүүн, хүч хэрэгслийг томилон үүрэг гүйцэтгүүлж болно.

Хилийн зөрчлийн ул мөр илэрмэгц заставын бэлтгэл хүчийг хүлээхгүйгээр хил зөрчигчийг мөрдөн хөөж саатуулах боломж хилийн харуулд бий. Гаднаас ямар ч хүч хүлээхгүйгээр хариуцсан хэсгийнхээ хилийг богино хугацааны дотор хаах боломж ч бий. Гагцхүү цагийн байдалдаа зохицуулан харуулын хүч хэрэгслийг бүрдүүлэх нь удирдлагын мэдрэмж мэдлэг чадвараас шалтгаалах зүйл юм.

Хилийн харуул томилон үүрэг гүйцэтгүүлэх нь тухай хэсгийг инженер техникийн байгууламж, хэрэгслүүдийг байнгын ажиллагаа хяналтад байлгах бас нэг нөхцөл мөн.

Харуулын даргаас хариуцсан хэсгийхээ хилийн бүс, зурваст байгаа иргэдийн дунд хилийн болон хил орчмын дэглэмийг

сахиулахтай холбогдсон арга хэмжээг байнга зохион байгуулж явуулах нөхцөлийг хилийн харуул бүрдүүлж өгнө.

Энэ мэтээр улсын хил хамгаалах үндсэн 5 арга хэмжээг (хилийн манаа, хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа, хилийн эрэл, цэрэг, инженер техникийн арга хэмжээ) хилийн харуул бие даан хэрэгжүүлж чадах учраас алс холын хэсэгт ганц нэгээр явсан хилийн манаанаас илт давуу бөгөөд улсын хил хамгаалалтын анхан шатны нэгж гэдэг нь тодорхой байна. Хилийн харуулын улсын хил хамгаалалтад эзлэх байр суурь ч үүгээр тодорхойлогдож байна.

Зах зээлийн үйл явц улсын хилийн цагийн байдалд хүчтэй нөлөөлснөөр ХЗЯБЧ (хил зөрчигч явж болзошгүй чиглэл), оператив чиглэлийг тодорхойлоход хүндрэлтэй болж хил хамгаалалтын хүч хэрэглсийн боломжийг хэд дахин нэмэгдүүлэхийг шаардах болов.

ХЗЯБЧ-ийг Хилийн цэргийг удирдах газар жилээр, хилийн отряд улирлаар, хилийн застав-хоногоор тодорхойлоод түүндээ бүх хүчээ төвлөрүүлдэг байв. Түүний хүчинд хилийн зөрчлийг цаг хугацаанд нь илрүүлэн шийдвэрлэж байлаа. Гэтэл өнөөдөр нэг талаас ХЗБЯЧ-ийг тодорхойлох үзүүлэлтүүд тохирохоо больж нөгөө талаас хилийн цэрэг өөрийн мэдлийн тагнуулын байгууллагагүй болсноос түүнийг улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах тушаал, удирдамжаа нэр зааж оруулах боломжгүй болжээ.

ХЗЯБЧ-ийг тодорхойлохдоо урьд нь удаа дараа хилийн зөрчил гэгч байсан чиглэлийг сонгон авдаг байлаа. Гэтэл сүүлийн үед гарч байгаа хилийн зөрчлийн ихэнх нь урьд өмнө хилийн зөрчил гарч байгаагүй чиглэлд гардаг болсноор энэ үзүүлэлт тохирохоо болив. Мөн хил зөрчигч нуугдан явж болох чиглэлийг ХЗЯБЧ гэж үзэж байв. Хурд маневр нь эрс өссөнтэй холбогдож хил зөрчигч хилийн манааны дэргэдүүр шууд дайрч гарах болсон нь ХЗЯБЧ-ийг тодорхойлоход бэрхшээл учруулж байна.

Хилийн зөрчлийг байгаль цаг уурын хамгийн тохиромжгүй үед гарна гэж үздэг байв. Гэтэл хил зөрчигчид сүүлийн үед байгаль цаг уурын таатай нөхцөлийг сонгодог болсон байна. Энэ мэтээр хил зөрчигч явж болзошгүй чиглэлийг тодорхойлоход туйлын төвөгтэй болсон нь шаардлагатай үед хариуцсан хэсгээ бүхэлд нь байнгын хяналтад авах бэлтгэлтэй байхыг шаардаж байна. Энэ нь байнгын хамгаалалтад байвал зохих хилийн хэсгийг урьдынхаас 2-3 дахин нэмэгдүүлээ гэсэн үг юм.

Энэ мэт нөхцөл байдлууд улсын хил хамгаалалтыг уян хатан, идэвхтэй, маневрлаг, чадварлаг байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл улсын хил хамгаалалтын эзлэх орон зай, цаг хугацаа, үйл

ажиллагааны цар хэмжээ, шинж байдал урьдынхаас өөрчлөгдөж байна гэсэн үг юм.

Ийм нөхцөл байдалд улсын хилд орон зай, цаг хугацааны хийдэгдэл гаргахгүй байхаар хил хамгаалалтыг зохион байгуулж болох тийм арга хэлбэрийг олж илрүүлэх шаардлагатай байна.

Улсын хил хамгаалалтын хөгжлийн үндэс нь гадаад, дотоод цагийн байдлын өрнөлт, хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлүүд, хүч хэрэгслийн боломж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах ур чадвар, тэдгээрийн харилцан шүтэлцээний үр дүн юм.

Хилийн цагийн байдал маш их өрнөсөн цаг үед өнөөгийн хил хамгаалалт явагдаж байна.

Улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэхийн тулд хүч хэрэгслийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирэв. Гэтэл улсын эдийн засаг ийм ачааллыг хүлээж авах боломжгүй бөгөөд харин ч хугацаат цэргийн албан хаагчдын тоо урьд байснаас 3 дахин цөөрсөн. Урьд нь бараг хамгаалалтгүй шахам байсан Монгол-Оросын хилийг өмнөд хилийн нэгэн адил хамгаалах болж, байгаа хүч хэрэгслээ нийт хилийн дагуу тараан байрлуулав. Түүнчлэн хилийн цэргийн жилийн хэрэгцээт төсвийн дөнгөж 40-50 хувь нь батлагдан гарч байна.

Ийм хүч хэрэгслээр хилийн заставын хариуцсан хэсгийг байнгын хяналтад байлгая гэвэл хилчдийн ачааллыг 4 дахин нэмэгдүүлэх буюу хоногт $8 \times 4 = 32$ цаг үүрэг гүйцэтгүүлнэ гэсэн үг юм. Гэтэл хоногт 24 цаг байдаг бөгөөд хүн бүтэн жилийн турш 24 цагаар үүрэг гүйцэтгэж чадахгүй нь хэнд ч ойлгомжтой.

Хилийн заставын хариуцсан хилийн хэсэг харилцан адилгүй боловч ихэнхдээ хилийн засталаас томилогдсон хилийн манаа хамгаалах хэсэгтээ хүрэхийн тулд ихэнх цагаа зарцуулаад тухайн хэсгийг хамгаалалтад байлгах хугацаа хэтэрхий бага байлаа. Ингэж хүн, уналга хоёрыг өдөржин зүтгүүлсэн ч хилээ хамгаалсан хугацаа нь өчүүхэн байв.

Улсын хилд үүсч бий болсон цагийн байдлыг үндэслэн төр засгаас хилийн бүх хэсгийг хяналтын нэгдсэн системд хамруулах бодлого явуулж байна. Тухайлбал, Монгол улсын Засгийн Газрын 1994 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан "Батлан хамгаалах үйл ажиллагаа, Зэвсэгт хүчин, бусад цэргийг шинэчлэх талаарх Засгийн газрын хөтөлбөр" -т "... Монгол-Хятадын хилийн бүх хэсгийг нэгдсэн хяналтад бүрэн хамруулна. . .", Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан "Цэргийн шинэчлэлийн бодлого" -д "Улсын хилээ эргэн

тойрон жигд хянаж чаддаг болж, хилийн зөрчлийн тухай мэдээлэл төвдөө хурдан ирж, түүний мөрөөр авах арга хэмжээг шуурхай болгоно" гэж тус тус заасан билээ.

Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн улсын хилийн хамгаалалтыг улам боловсронгуй болгох эрэл хайгуулын явцад хилийн цэрэг дахин байгуулагдсан 1960-ад оноос хил хамгаалалтад ашиглагдаж ирсэн хилийн постыг улам хөгжүүлж шинэ агуулгаар баяжуулан ашигласнаар илүү үр дүнд хүрч болно гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Хошууч генерал П.Даш

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТЭМДГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Монголчууд эрт дээр үеэс нутаг бэлчээр, засаг захирагааныхаа нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоож, онцгойлон таних тэмдгээр тэмдэглэж ирсэн түүхтэй билээ.

Хилийн цэсийг тэмдэглэхдээ уулын хяр, орой, гуу жалга, гол мөрөн, худаг, булаг шанд, сондгой хад, чулуу, ганц мод зэрэг газар орны янз бүрийн онцлогийг ашиглахаас гадна хилийн цэсийг улам тодорхой болгохын тулд нэмэгдэл овоо тэмдэг босгодог байжээ.

Монгол Улсын хилийн тэмдгийн үүсэл нь 1727 оны Буурын гэрээгээр тогтоогдсон хилийн дагуух овоонуудаас эхлэлтэй гэж үзэж болно. Эдгээр хилийн овоо нь одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дахь "Дундын овоо" түүнээс баруун, зүүн тийш хилийн дагуу босгосон хос чулуун болон шороон овоонууд юм. Хилийн овоонууд нь дан, хосоор байх ба ихэвчлэн чулуун болон шороон овоо байдаг.

Манж Оросын хооронд байгуулсан Буурын гэрээгээр Монгол Улсын хойд хилийн дагуу Дундын Овооноос зүүн тийш Тарваган Дахын Овоо хүртэл 58 овоо, баруун тийш Монгол Шарын Даваа хүртэл 18 овоо босгосон байна. Тарвагатайн гэрээгээр Алтайн Таван Богд Уулын 4104.0 тоот өндөрлөгөөс Асгатын давааны хярын орой хүртэл 6 овоо, бүгд хилийн 86 овоог мөн босгожээ.

Буурын гол болон Тарвагатайн Гэрээгээр тогтоосон хилийн баримт бичигт хилийн овоонуудыг хаана босгосон, дэс дараанд оруулж дугаарласан, хэлбэр, төрлийг нь тодорхойлсон байдаг. Харин хилийн нэг овооноос дараагийн овоо хүртэл хилийн шугамын байршлын талаар, зай хэмжээг хэрхэн тусгасан нь тодорхойгүй байдаг тул